

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ  
ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2026.03.31 № 01/67  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

“СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ” ХХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
НЯГТЛАН БОДОГЧ



Б. АЗЖАРГАЛ  
Б. БИНДЭРЪЯА

## БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр	<p>Си И Си Инвестмент ББСБ ХХК нь 2013 оны 11 сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагчийн шийдвэрийн дагуу Монгол улсын хуулийн хүрээнд үүсгэн байгуулагдаж Монгол Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт 2013 оны 11 сарын 06-ны өдөр бүртгэгдсэн.</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9015005056. Компанийн регистрийн дугаар 5765919.</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг.</p>
Үндсэн үйл ажиллагаа	<p>Зээл олгох Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх</p>
Хувьцаа эзэмшигч	<p>Монгол улсын хуулийн этгээд Си И Си Групп ХХК нь энгийн хувьцааг 100 хувь эзэмшдэг.</p>
Засаглах этгээдийн мэдээлэл	<p>ТУЗ-ийн дарга Х.Гиймаа ТУЗ-ийн гишүүн Ц.Ууганбаяр ТУЗ-ийн гишүүн Н.Урантуяа ТУЗ-ийн гишүүн П.Ундрах-Эрдэнэ ТУЗ-ийн гишүүн Б.Баярмаа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Батцэцэг</p>
Гүйцэтгэх удирдлага	<p>Гүйцэтгэх захирал Б.Азжаргал Нягтлан бодогч Б.Биндэръяа</p>
Тусгай зөвшөөрөл	<p>Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл Т3101/399</p>
Бүртгэлтэй хаяг	<p>Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Нью хоризонс оффис, 7 дугаар давхар</p>
Аудиторууд	<p>Мүүрь Аудит ХХК Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид</p>

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

#### Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

##### Дүгнэлт

Бид, Си И Си Инвестмент ББСБ ХХК-ийн (цаашид Компани гэх) 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

##### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

### Зээл ба зээлийн эрсдэлийн сан

Компани тайлант оны эцсээр 15,424,971 (2024: 9,536,111) мянган төгрөгийн зээлийн авлагатай ба уг зээлд 620,804 (2024: 136,674) мянган төгрөгийн хүлээгдэж байгаа зээлийн эрсдэлийн сан байгуулсан.

Бид аудитын явцад гэрээний нөхцөлүүдийг судалж, орлого хүлээн зөвшөөрөлт, гэрээний үүргийн биелэлт, хүлээн аваагүй хүүгийн орлогын үлдэгдэл үнэн зөв эсэхийг хянаж, зээлийн ангилал, зээлийн үлдэгдэл үнэн зөв эсэхийг баталгаажуулах горим хэрэгжүүлсэн. Хүлээгдэж байгаа эрсдэлийн сангийн тооцооллыг давтан гүйцэтгэж, бодлогоо тууштай мөрдөж байгаа эсэхийг үнэлсэн. Бидний олж авсан ойлголт, хэрэгжүүлсэн горим сорил, цуглуулсан баримт нотолгоонд суурилан тайлант хугацааны орлого хүлээн зөвшөөрөлтийн процесс ба зээл, зээлийн эрсдэлийн сан нь материаллаг буруу илэрхийлэл агуулаагүй гэж үзсэн.

### Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу компанийн үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд



- хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
  - Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
  - Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
  - Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитаар илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.


Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид шаардлагатай гэж үзвэл харилцаа холбоо, аюулгүй байдал зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг. Эдгээр асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт Санхүүгийн зохицуулах хороонд бэлтгэж өгсөн санхүүгийн мэдээлэл, жилийн тайланг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлан болон манай аудитын тайлан нь бусад мэдээллийг хамрахгүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй.




Си И Си Инвестмент ББСБ ХХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бусад мэдээлэл нь бидний аудитласан дүнгээс материаллаг зөрүүгүй байна. Тиймээс бусад мэдээллийн талаар тайлагнах зүйлс байхгүй.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын Компанийн тухай хуулийн 5 -р зүйлд заасан Си И Си Инвестмент ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.




**Хаяг:** Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Центрум төв, 7 давхар 701 тоот. **Утас:** 976-70150003, **И-мэйл:** [info@moore-mongolia.mn](mailto:info@moore-mongolia.mn)



## АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан 2025 ₮'000	Аудитлагдсан 2024 ₮'000
Хүүгийн орлого	7	5,573,205	2,371,620
Хүүгийн зардал	8	(1,537,042)	(395,314)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>4,036,163</b>	<b>1,976,306</b>
Эрсдэлийн сан-цэвэр	13	484,130	114,923
<b>Эрсдэлийн сангийн дараах хүүгийн цэвэр орлого</b>		<b>3,552,033</b>	<b>2,091,229</b>
Хүүгийн бус орлого	9	314,584	171,578
Хүүгийн бус зардал	10	(2,214,427)	(837,207)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>1,652,19</b>	<b>1,425,600</b>
Орлогын татварын зардал	11	(163,431)	(138,784)
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		<b>1,488,759</b>	<b>1,286,816</b>



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.


**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тод.	Аудитлагдсан 2025 ₮'000	Аудитлагдсан 2024 ₮'000
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Санхүүгийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	12	7,545,328	1,040,303
Харилцагчдад олгосон зээл	13	14,804,167	9,399,437
Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө	14	364,168	743,304
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	14	1,177,722	-
Бусад санхүүгийн хөрөнгө	15	1,122,316	298,529
		<b>25,013,701</b>	<b>11,481,573</b>
<b>Санхүүгийн хөрөнгийн дүн</b>			
<b>Санхүүгийн бус хөрөнгө</b>			
Урьдчилж төлсөн тооцоо	16	53,269	-
Бараа материал	16	1,000	1,100
Бусад санхүүгийн бус хөрөнгө	16	73,287	72,287
Үндсэн хөрөнгө	17	107,000	283,077
		<b>364,171</b>	<b>356,464</b>
		<b>25,377,872</b>	<b>11,838,037</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Санхүүгийн өр төлбөр</b>			
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	18	6,644,637	2,437,785
Бусад санхүүгийн эх үүсвэр	18	2,135,965	2,027,629
Бусад өглөг	18	770,537	61,818
		<b>9,551,139</b>	<b>4,527,232</b>
<b>Санхүүгийн өр төлбөрийн дүн</b>			
Орлогын албан татварын өр	19	222,648	151,563
Бусад татвар, НДШ-ийн өр	19	31,161	8,600
Бусад өглөг	19	190	-
		<b>253,999</b>	<b>160,163</b>
		<b>9,805,138</b>	<b>4,687,395</b>
		<b>15,572,734</b>	<b>7,150,642</b>
<b>Өмч:</b>			
Хувьцаат капитал	20	12,000,000	4,400,000
Хуримтлагдсан ашиг	21	3,528,120	2,750,642
Бусад өмч	20	44,614	-
		<b>15,572,734</b>	<b>7,150,642</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Хувьцаат капитал ₮'000	Эздийн өмчийн бусад хэсэг ₮'000	Хуримтлагд- сан ашиг ₮'000	Нийт ₮'000
<b>2024.01.01-ний үлдэгдэл</b>	<b>4,400,000</b>	-	<b>1,463,826</b>	<b>5,863,826</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	1,286,816	1,286,816
<b>2024.12.31-ний үлдэгдэл</b>	<b>4,400,000</b>	-	<b>2,750,642</b>	<b>7,150,642</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	1,488,759	1,488,759
Ногдол ашиг	-	-	(666,667)	(666,667)
Нөөц сангийн бууралт (өсөлт)	-	44,614	(44,614)	-
Эздийн өмчид гарсан өөрчлөлт	7,600,000	-	-	7,600,000
<b>2025.12.31-ний үлдэгдэл</b>	<b>12,000,000</b>	<b>44,614</b>	<b>3,528,120</b>	<b>15,572,734</b>




Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	Тод.	Аудитлагдсан 2025 ₮'000	Аудитлагдсан 2024 ₮'000
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>1,425,600</b>	<b>753,052</b>
<i>Тохируулга:</i>			
Зээлийн эрсдэлийн сангийн орлого	13	(484,130)	(114,923)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	17	55,414	36,470
ААБҮЦ-ээрх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	10,14	-	(72,520)
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10	108,663	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус ашиг (алдагдал)	10	(7,447)	(1,492)
Бусад санхүүгийн хөрөнгийн ҮЦБ	15	-	9,153
Хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		6,675	776
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>			
Зээлийн авлагын өсөлт		(4,920,600)	(5,361,807)
Урьдчилж төлсөн тооцооны бууралт		(53,269)	2,500
Хуримтлуулсан хүүгийн өглөгийн өсөлт		254,947	70,743
Хуримтлуулсан хүүгийн авлагын өсөлт		-	(28,623)
Бараа материалын өсөлт (бууралт)		100	(1,100)
Бусад авлагын бууралт (өсөлт)			(65,945)
Бусад санхүүгийн бус хөрөнгийн бууралт (өсөлт)		(1,000)	-
Бусад өр төлбөрийн өсөлт (бууралт)		545,951	19,129
Төлсөн татвар		(92,436)	(82,157)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(2,934,852)</b>	<b>(4,164,196)</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17	(133,212)	(55,761)
Хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		247,200	1,898
Үнэт цаас худалдан авахад төлсөн	14	(798,587)	(17,014)
Хөрөнгө оруулалт худалдаж авахад төлсөн	14	(823,787)	-
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(1,508,386)</b>	<b>(70,877)</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Гаргасан бонд	18	-	1,975,355
Гаргасан хувьцаа	18	7,000,000	-
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан мөнгө	18	4,110,000	2,269,000
Ногдол ашиг	18	(66,667)	-
Төлсөн түрээс	18	(102,518)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>10,940,816</b>	<b>4,244,355</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		6,497,578	9,282

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12	1,040,303	1,029,529
Валютын ханшийн зөрүү		7,447	1,492
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b><u>7,545,328</u></b>	



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.